



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Хөгжлийн хөтөч дэд бүтэц” төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 286,190,000.00 (хоёр зуун наян зургаан сая нэг зуун ерэн мянга) төгрөгийн балансын үнэ, 54,853,083.34 (тавин дөрвөн сая найман зуун тавин гурван мянга наян гурван төгрөг гучин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дашпүрэв, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Хөгжлийн хөтөч дэд бүтэц төслийн зохицуулагч Ж.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3 Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны ...~~81~~... дугаар сарын...~~17~~... өдрийн
~~15~~... дугаар тогтоолын хавсралт

**“ ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ДЭД БҮТЭЦ” ТӨСЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМАНД
 БАЛАНСААС БАЛАНСАД ШИЖЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны нэр, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуризмтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ланд-Круйзер 200, улсын дугаар 0374 УНУ	2021	286,190,000.00	54,853,083.34	231,336,916.66
Нийт дүн			286,190,000.00	54,853,083.34	231,336,916.66
			(хоёр зуун наян зургаан сая нэг зуун ерэн мянга)	(тавин дөрвөн сая найман зуун тавин гурван мянга наян гурван төгрөг гучин дөрвөн мөнгө)	(хоёр зуун гучин нэгэн сая гурван зуун гучин зургаан мянга есөн зуун арван зургаан төгрөг жаран зургаан мөнгө)